

БАТЛАВ

МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН  
ШАДАР САЙД БӨГӨӨД  
ЭДИЙН ЗАСАГ ХӨГЖЛИЙН  
САЙД

БАТЛАВ

САНГИЙН САЙД

БАТЛАВ

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД

Л.ГАНТӨМӨР

Б.ЖАВХЛАН

О.АЛТАНГЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬ (ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА)-ИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

### Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн төслийг боловсруулах дараах хууль зүйн үндэслэл болон практик шаардлага үүсээд байна. Үүнд:

#### 1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлаас Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийг 2011 оны 02 дугаар сарын 10-ны өдөр баталж, тус хуулийг банкны засаглалыг сайжруулах, хараат бус, бие даасан байдлыг нэмэгдүүлэх, үндсэн үйл ажиллагааны чиглэлийг өргөжүүлэх зорилгоор 2017 оны 02 дугаар сарын 10-ны өдөр тус хуулийн шинэчлэн баталсан байдаг.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” 106 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан Монгол Улсын Их Хуралд 2022 онд үе шаттайгаар өргөн мэдүүлэх хуулийн төслийн жагсаалтад “Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг өргөн мэдүүлэхээр тусгасан. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны “Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн зээл олголт, эргэн төлөлтийн явцад хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын 2023 оны 26 дугаар тогтоолоор “... Хөгжлийн банкныг цогцоор нь иж бүрэн өөрчлөн зохион байгуулж, хууль тогтоомжид өөрчлөлт оруулах төслийг боловсруулж, 2023 онд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, ... хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, ... холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх” үүргийг Засгийн газарт даалгасан.

Монгол Улсын Их хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1 дүгээр зүйлийн 3.1.3.8-т “хөгжлийн банкны үйл ажиллагааг экспорт импортын банк болгон өргөжүүлэх, засаглалыг сайжруулан...” гэж, Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан 2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тухай 01 дүгээр албан даалгаврын 3.2-т “Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагааг экспорт-импортын банк болгон өргөжүүлэх, зохион байгуулах,

засаглалыг сайжруулах”-ыг тус тус зохицуулсан байдаг.

Иймд Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагааг экспортын орлогыг нэмэгдүүлэх, импортыг орлох үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгын хүрээнд эрх зүйн орчныг боловсронгуй болгохыг даалгасан тул Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн төслийг боловсрууллаа.

## 1.2 Практик шаардлага

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 2017 оны шинэчилсэн найруулгын хүрээнд “Монгол Улсын Хөгжлийн банкныг үндэсний эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах тэргүүлэх салбаруудад хэрэгжих төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх, импортыг орлох, экспортын орлогыг нэмэгдүүлэх үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилготой” байхаар өөрчилсөн.

Тус өөрчлөлт нь Хөгжлийн банкнаас санхүүжүүлж болох төсөл, хөтөлбөрийн хүрээг хумьж, 2016-2016 оны хооронд төсвийн хөрөнгө оруулалтаар хийх боломжгүй төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй эдийн засгийг төрөлжүүлэхэд шаардлагатай эрчим хүч, зам харилцаа, аж үйлдвэрлэлийн цогцолбор, хот төлөвлөлтийн болон боловсруулах үйлдвэрүүдийн томоохон төслүүдийг санхүүжүүлэх боломжгүй бөгөөд зөвхөн тэргүүлэх салбаруудад хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт хамаарах болсон.

Ингэхдээ 2011 оны Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1-т заасан “Засгийн газрын баталсан Монгол Улсын хөгжлийн тэргүүлэх болон стратегийн ач холбогдол бүхий салбарт хамаарах төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх гэснийг хасаж 2017 оны Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т “Засгийн газар хөгжлийн банкны эх үүсвэрээр санхүүжүүлэх төсөл хөтөлбөрийг тусгайлан батлахгүй” гэж оруулсан нь **“тэргүүлэх салбар”** гэдэгт ямар төсөл, хөтөлбөрийг хамруулан санхүүжүүлэхийг Хөгжлийн банкны төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын зүгээс дур мэдэн шийдвэрлэх боломж бүрдсэн.

Өнгөрсөн хугацаанд дээрх тодорхойгүй байдлын улмаас Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрүүдийн дийлэнх нь Монгол Улсын хөгжлийн банкны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т “үндэсний эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, тэргүүлэх салбаруудад хэрэгжих төсөл, хөтөлбөр”-т хамаарахгүй, түүнчлэн арилжааны банкнаас санхүүжүүлэх бүрэн боломжтой эсхүл тэдний олгосон чанаргүй зээлийг дахин санхүүжүүлсэн, мөн эдийн засгийн үр ашиггүй төслүүд байсан ба үүний улмаас Хөгжлийн банкны санхүүгийн үзүүлэлтүүд хүндрэх, холбогдох албан тушаалтан, зээлдэгчийн зүгээс гэмт хэрэг үйлдэх урьдчилсан нөхцөл болсон байна.

Өнгөрсөн хугацааны Хөгжлийн банкны санхүүгийн үзүүлэлт, зээлийн чанар, болон холбогдох байгууллагуудаас хийсэн хяналт шалгалтын дүгнэлтээс үзэхэд банк нь хуулиар хүлээсэн чиг үүргээ хангалттай хэрэгжүүлж ажиллахгүй байгаа нь дээр дурдсан бодлогын өөрчлөлтөөс гадна дараах хуулийн зохицуулалтуудаас шалтгаалж байна:

1.Хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д Хөгжлийн банкнаас хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрт тавигдах шалгуур шаардлагыг тодорхойлохдоо “тендерт оролцогч аж ахуйн нэгжид Өрийн удирдлагын тухай хуулиар тавьдаг шалгууртай ижил стандарт”-ыг баримталж ерөнхий бөгөөд хатуу шаардлагууд тавьсан нь тус банкны төлөөлөн удирдах зөвлөлөөс төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх бодлого, стратегийг салбарын болон бизнесийн онцлог, хэрэгжүүлэх төслийн бүтэц, санхүү, хөрөнгө оруулалтын тооцоолол, төсөл хэрэгжүүлэгчдийн хоорондын гэрээний нөхцөл, гадаад дотоодын зах зээлийн өөрчлөлттэй нийцүүлж, гадаад, дотоод зах зээлийн өөрчлөлт, нөхцөл байдалтай нийцүүлж өөрчлөх, шинэчлэх боломжгүй байдалд хүргэсэн.

Тухайлбал, хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1-т “Монгол улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцсэн, эдийн засаг, санхүүгийн үр ашигтай байх”, мөн зүйлийн 10.2-т “энэ хуулийн 10.1-т заасан шаардлага хангасан төсөл, хөтөлбөрийг дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулагчидтай хамтран санхүүжүүлэх”, хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т “баталгаа батлан даалтыг 10.1.2-10.1.5-д заасан шаардлага хангасан төсөл, хөтөлбөрт гаргах”-аар хязгаарласан зэрэг нь Хөгжлийн банк бизнесийнхээ хувьд бусдаас хэт хамаарсан, зорилтот зах зээлийнхээ нөхцөл байдалд тохируулан үйл ажиллагаагаа эрхлэх боломжийг хаасан.

Тиймээс Хөгжлийн банкны үйл ажиллагааг зохицуулсан бодлогын баримт бичиг, журам, аргачлалыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандарт аргачлалаар баталж, хэрэгжүүлэх боломжийг олгосон буюу банк өөрийн үйл ажиллагааны стратеги, ажил, үйлчилгээний онцлогт нийцсэн хөрөнгө оруулалт, санхүүжилт, эрсдэлийн болон дотоод хяналтын бодлого, журмыг боловсруулан төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулж дагаж мөрдөх, үйл ажиллагаандаа хяналт тавьдаг байх боломжийг хуулиар бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

2.Шинэчилсэн найруулгын төсөлд Монгол Улсын Хөгжлийн банкны зорилтыг Монгол улсын тогтвортой хөгжлийг хангах эдийн засгийн өсөлтийг бий болгох зорилго-экспортыг дэмжих төсөл хөтөлбөрийг санхүүжүүлж, экспорт, импорт, худалдааны санхүүжилтийн цогц үйлчилгээ үзүүлэх бодлогын банк байхаар шинэчлэн найруулж, эрхлэх санхүүгийн ажил үйлчилгээг хуулийн төслийн 14-25 дугаар зүйлүүдэд нарийвчлан тодорхойлно. Ингэснээр Хөгжлийн банкны экспорт, импортын санхүүжилт хийх ажил, үйлчилгээ өргөжиж, бодит байдлаар хэрэгжих боломж бүрдэнэ.

3.Хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т “Засгийн газар Хөгжлийн банкны эх үүсвэрээр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийг тусгайлан батлахгүй.” гэж өөрчлөлт орсноос хойш Хөгжлийн банкнаас 1.6<sup>1</sup> их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний шууд санхүүжилтийг олгосон боловч энэ дунд нэх бүхий 3 төслөөс бусад нь тухайлсан нэг компанийн бизнесийг тэлэх, үйлдвэрлэл, үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлэх корпорацын буюу байгууллагын санхүүжилтийн хэлбэртэй байна.

Гэтэл Хөгжлийн банкны зорилт нь дотоодын санхүүгийн байгууллагын зах зээл дээр өрсөлдөх бус харин бодлогын банкны хувьд банк, санхүү, хөрөнгийн зах зээлийн оролцогчидтой хамтарч, тэдний гүйцэтгэж хараахан чадахгүй байгаа сегмент дээр хамтарсан санхүүжилтийн арга хэрэгслээр оролцон санхүүгийн зах зээлийн дутуу орон зайг нөхөх замаар Монгол улсын санхүү, эдийн засгийн орчны тогтвортой хөгжлийг хангах зорилгоор Монгол Хөгжлийн банкны тухай хуулийн

---

<sup>1</sup> Арилжааны банкнуудаар дамжуулан хөтөлбөр хэлбэрээр олгосон 438.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийн дүнг оруулаагүй болно.

шинэчилсэн найруулгын төсөлд 6-8 дугаар зүйлүүдийг нэмж хөгжлийн банкны зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл эрх хэмжээг тодорхой болгоно.

Засгийн газраас Монгол улсын тогтвортой хөгжлийн зорилтыг хангах зорилгын үүднээс аль салбарт ямар зорилтот төсөл хэрэгжүүлэх, үүнд Хөгжлийн банкны гүйцэтгэх үүргийг тодорхой зааж, шийдвэр гаргах бөгөөд тухайлсан зорилтыг хангахын тулд банк өөрөө бизнесийн төслийг эрж, олох, сонгож, судлах, хөгжүүлэх, сайжруулах, төслийн санхүүжилтийг зөвхөн санхүү, хөрөнгө оруулалтын шинжилгээ, судалгаанд үндэслэн бие даан шийдвэрлэх, олгосон санхүүжилтийн гүйцэтгэлд хяналт тавих, эрсдэлээс сэргийлэх, бууруулах арга хэмжээ авдаг байх үүргийг хуульчилна.

4.Хөгжлийн банк төрөлжсөн банкны нэг хэлбэр тул үйл ажиллагааг нь арилжааны банканд хяналт хэрэгжүүлдэг аргачлалаар хянаж, зохицуулж байгааг өөрчилж, төслүүдийн эдийн засгийн үр нөлөө, өгөөж, санхүүжилтийн ашигт байдлыг үнэлж, дүгнэх зарчмыг тогтоож, УИХ, Засгийн газар, Монголбанкны хяналт, дотоод аудитын зааг ялгааг нарийвчлан заасан хяналтын шинэ тогтолцоог бий болгоно.

5.одоогийн хүчин төгөлдөр хуулийн зохицуулалт нь банкны удирдлагад засаглалын зарчим алдагдахад хүргэснийг энэхүү шинэчилсэн найруулгаар засаж сайжруулна. Компанийн тухай хууль болон олон улсын компанийн сайн засаглалын зарчим, Монгол улсын Санхүүгийн зохицуулах хорооноос батлан мөрдүүлж буй “Компанийн засаглалын кодекс”-ын дагуу Төлөөлөн удирдах зөвлөл нь банкны урт, дунд хугацааны хөгжлийн стратегийг оновчтой тодорхойлдог, энэ хүрээнд банкнаас баримтлах зээл, санхүүжилт, хөрөнгө оруулалтын бодлого журмыг баталж, банкны үйл ажиллагаа хэвийн, тогтвортой үргэлжлэх нөхцөлийг хангаж чадахуйц эрсдэлийн болон хяналт, нийцлийн тогтолцоог бүрдүүлж, Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаанд хяналт тавьж ажилладаг болгоно.

Үе үеийн Төлөөлөн удирдах зөвлөл энэ үүргээ хангалтгүй биелүүлж ирсэн бөгөөд Гүйцэтгэх удирдлагын томилгоо, өдөр тутмын үйл ажиллагаанд оролцож, үнэт цаас гаргах (13.1); зээл авах (9.1.)-д шууд оролцож, нийт активын 0.6 хувиас дээш үнийн дүнтэй гэрээ, хэлцэл хийх шийдвэрийг гаргадаг зэрэг нь засаглалын зарчимтай зөрчилдөж, зээлийн шийдвэрт нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлж байна. Энэ дараах сөрөг үр дагаварт хүргэсэн байна.

а) зээл, санхүүжилтийн шийдвэр нь эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын шинжилгээ судалгаанд тулгуурлахгүй, улс төрийн болон удирдлагын нөлөөллөөр гарах эрсдэлийг бий болгосон;

б) банкны үйл ажиллагаа нь хууль, дүрэм, журамд нийцсэн байх нийцлийн (комплайнс) удирдлагын тогтолцоо алдагдаж, санхүү, үйл ажиллагаа, улс төр, нэр хүндийн эрсдэлд оруулсан;

в) төслийн санхүүжилтийн талаарх ойлголт сул, удирдлагын болон ажиллагсдын төслийг эрсдэлгүй удирдаж, хэрэгжүүлэх мэргэжлийн ур чадвар дутмаг, хүний нөөцийн чадамж бүрдээгүй,

г) хуульд төслийг үнэлэх, эрсдэлээс сэргийлэх зорилгоор банкнаас авах арга хэмжээг тодорхой зохицуулаагүйн улмаас Хөгжлийн банкны үүрэг, зорилгыг буруугаар ашиглаж, их хэмжээний чанаргүй зээл бий болох, Засгийн газраас хувь нийлүүлсэн татвар төлөгчдийн мөнгөн хөрөнгө болон хөрөнгө оруулагчдын

оруулсан мөнгөн хөрөнгө үнэгүйдэх нөхцөлийг бий болгосон г.м.

6. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн бүтэц, эрхлэх үйл ажиллагааны цар хүрээ нь ашгийн төлөө арилжааны банкны үйл ажиллагаатай ойролцоо зохицуулалттай, зөвхөн харилцах, хадгаламж татан төвлөрүүлэхгүй, нэг зээлдэгчид олгох зээлийн хэмжээ өөрийн хөрөнгийг 8 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх арай их хэмжээтэй байгаагаараа л ялгаатай байна.

Харин бусад улсын туршлагаас үзэхэд хөгжлийн банк нь тодорхой салбарыг зорилготойгоор (экспортын чадамжтай болгох г.м) дэмжсэн төсөлд төрөөс үүсгэн байгуулсан сангаар дамжуулан хөрөнгө оруулах хийх, экспортын даатгал, баталгааны үйлчилгээ үзүүлэх, арилжааны бус нөхцөлтэй санхүүгийн үйлчилгээгээр ирээдүйд өсөлт авчрах салбарын жижиг, дунд хэмжээний бизнесийг дэмжих зэрэг үйлчилгээ өргөн хүрээнд үзүүлж үйл ажиллагаагаа явуулдаг байна. Энэ чиглэлээр Хөгжлийн банкны одоогийн зохицуулалт хангалтгүй, сүүлийн 6 жилийн хугацаанд дорвитой өөрчлөлт хийгдээгүй болно.

Дээр дурдсан алдааг гаргахгүй байх зорилгоор Монгол Улсын Хөгжлийн банкны эрх зүйн байдлыг тогтоосон хуульд зарчмын хэд хэдэн өөрчлөлтийг оруулж, хөгжлийн болон төслийн санхүү, экспорт, импортын санхүүжилттэй холбоотой харилцаа, ажил үйлчилгээг энэ хуулиар нарийвчлан зохицуулах зайлшгүй шаардлагатай болсон.

Ингэхдээ Монгол Улсын макро эдийн засгийн эмзэг, тогтворгүй байдал, төсвийн орлогын савлагаа, түүхий эдээс хамааралтай дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх эдийн засгийн салбаруудын харьцангуй өөр өөр түвшнийг ойртуулах хэрэгцээ шаардлагыг харгалзаж, ирээдүйд өсөлт бий болгох зорилтот салбаруудыг төрөөс дэмжин хөгжүүлэх Алсын хараа-2050 бодлогод нийцүүлэн, төсвийн хөрөнгө оруулалтын бодит боломж ба санхүүгийн салбарын институтийн чадамж, эх үүсвэрийн хүртээмж, нөхцөлийг тооцоолон Хөгжлийн банкны эдийн засагт үзүүлэх үр нөлөөллийг монгол Улсын хөгжлийн зорилтот зах зээл рүү чиглүүлж экспортын дэмжих, эдийн засгийг тогтворжуулах, тэнцвэржүүлэх тусгай (төрөлжсөн бус) чиг үүрэгтэй байхаар эрх зүйн байдлыг нарийвчлан тодорхойлно.

### **Хоёр. Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь 10 бүлэг, 46 зүйлээс бүрдэх бөгөөд дээр дурдсан хууль зүйн болон практик шаардлагад үндэслэн дараах агуулгаар шинэчлэн найруулна:

1.Хуулийн төслийн Нэгдүгээр бүлэгт хуульд хэрэглэгдэх санхүүгийн ажил, үйлчилгээний талаарх ойлголтыг энэ хуульд хэрэглэх нэр томъёоны 4 дүгээр зүйлээр нэмж тодорхойлов.

2.Монгол Улсын Хөгжлийн банкны эрх зүйн байдлыг тодорхойлсон хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт банкны эрх зүйн статусыг “Хөгжлийн банк нь энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан хөгжлийн зорилтыг дэмжих чиг үүрэг бүхий төрөөс үүсгэн байгуулсан хөгжлийн институт мөн” гэж өөрчилж банкны үйл ажиллагаа явуулах хэлбэрийг тодорхойлов.

3.Монгол Улсын Хөгжлийн банкны зорилт, эрхлэх үйл ажиллагааны чиглэл,

эрх хэмжээг 6, 7, 8 дугаар зүйлүүдэд тодорхой заасан.

4.Монгол Улсын Хөгжлийн банкны зарчим, хориглох үйл ажиллагаа, хөгжлийн банканд тавигдах шаардлагыг 11, 12, 13 дугаар зүйлүүдэд шинээр оруулсан.

5.Хөгжлийн банкны эрхлэх санхүүгийн ажил үйлчилгээг банкны зорилго, зорилттой нийцүүлэн хуулийн гурав дугаар бүлэгт буюу 14-23 дугаар зүйлүүдэд шинэчлэн тодорхойлсон.

Мөн 24, 25 дугаар зүйлүүдэд тогтвортой, ногоон бодлогыг дэмжсэн ногоон санхүүжилт олгох болон экспортыг дэмжих зорилгоор экспортын санхүүжилт, экспортын зээлийн баталгаа гаргах, даатгал хийхтэй холбоотой ажил үйлчилгээг нэмж тусгав.

6.Хөгжлийн банкны үйл ажиллагаанд засаглалын тогтвортой байдал, шийдвэр гаргалтын эрх хэмжээг зөв хуваарилах, үүрэг, хариуцлагыг тодорхой зааж өгөх зорилгоор Хөгжлийн банкны төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, тэдгээрийг томилох чөлөөлөх асуудлыг 26 дугаар зүйл, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд тавигдах шалгуурыг 27 дугаар зүйл, төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг 30 дугаар зүйлүүдэд шинэчлэн найруулж, төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны талаар 29 дүгээр зүйлийг нэмсэн.

7.Гүйцэтгэх захирлын хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх асуудлыг 31 дүгээр зүйлд, гүйцэтгэх захиралд тавигдах шалгуурыг 32 дугаар зүйлээр, гүйцэтгэх захирлын эрх, үүргийг 33 дугаар зүйлүүдэд тус шинэчлэн найруулсан.

8.Хөгжлийн банкны үйл ажиллагаанд Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх, Засгийн газрын бүрэн эрх, Монголбанкны хяналтыг ойлгомжтой болгох зорилгоор Тав дугаар бүлэгт Хөгжлийн банкнаас бусадтай харилцах зарчмыг ойлгомжтой болгож өөрчилж, бусад байгууллагуудын Хөгжлийн банкны талаар эдлэх эрхийг тодорхой болгов.

9.Хөгжлийн банк чанаргүй активын эрсдэлийг бууруулах зорилгоор эрсдэлтэй активт бүтцийн өөрчлөлт хийх, банкны мэргэжлийн байгууллагуудын ашигладаг арга хэрэгслийг ашиглах талаар 41 дүгээр зүйлд нэмж тусгаж, арга хэмжээ авах заалт оруулав.

10.Банкнаас санхүүжүүлсэн, санхүүжүүлэх төслийн үйл явц, хэрэгжилтийн байдал, санхүүжилтийн талаарх мэдээллийг нээлттэй, ил тод болгох заалтыг 43.4 дэх хэсэгт нэмж тусгана.

**Гурав. Хууль батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Энэ хуулийн төсөл батлагдсанаар банкны үйл ажиллагаа сэргэж, эрхлэх үйл ажиллагаа, эрх хэмжээ, үүрэг хариуцлага, засаглалын тогтолцоо нь олон улсын стандартад нийцэх бөгөөд зээл, төслийн санхүүжилт олгохдоо илүү хариуцлагатай, мэргэжлийн судалгаа тооцоон дээр үндэслэж, санхүүжилтийн шийдвэрийг бие даасан байдлаар гаргадаг болно.

Шинэ сэргэлтийн бодлого, Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх эх үүсвэр бүрдүүлэх, санхүүжилт олгоход байгууллагын үйл ажиллагааг бэлтгэн хүний нөөцийг чадавхыг сайжруулах, удирдлагын тогтолцоог эрсдэлийн үнэлгээ, хууль тогтоомжийн нийцлийн шалгуур, шаардлагад нийцүүлэн үйл ажиллагааг богино хугацаанд өргөжүүлж, олон нийтийн банканд итгэх итгэлийг өсөж, банкны нэр хүндийг сайруулах боломж бүрдэнэ.

**Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал**

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай нийцсэн байх бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Зөрчлийн тухай, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төв банк/монголбанк/-ны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Үндэсний баялгийн сангийн тухай хууль, Банкны тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулиудад энэ хуулийн төслийг даган өөрчлөлт орох бөгөөд 2017 оны 02 дугаар сарын 10-ны өдөр батлагдсан Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн боловсруулагдана.

-оОо-